Цагдаагийн ерөнхий газрын даргын
2023 оны 12. дугаар сарын 27.-ны өдрийн
А/401. дугаар тушаалын хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

**Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:**

[√] Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

[ ] Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

**Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:**

**Дагаж мөрдөх огноо:**

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:** 2023.12.27

| | |
|---|---|
| **Байгууллагын нэр:** | **Нэгжийн нэр:** |
| Цагдаагийн ерөнхий газар | Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага |
| **Албан тушаалтны нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл:** |
| Хэв журмын ажил хариуцсан чиглэлийн ахлах байцаагч | ТТ-5 |
| **Ажлын цаг:** | **Ажлын байрны албан ёсны нэршил:** |
| 8 цаг | Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын байр |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах. |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ.

**Албан тушаалын зорилго:**
Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомж нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, хяналт тавих, алба хаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийг гүйцэтгэх, дүүргийн хэмжээнд зохион байгуулах, байгууллага, алба хаагч, бусад ажиллагсдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.

**Албан тушаалын зорилт:**
1.Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдан зохион байгуулах, үр дүнг нэгтгэх, тооцох.

| |
|---|
| 2.Нийтийн хэв журам хамгаалах тасгуудын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, алба хаагчдын мэдлэг, ур чадварын түвшнийг дээшлүүлэх, алба хаагчдын сахилга, ёс зүйн байдалд хяналт тавих.<br>3.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. |

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | **Хариуцлага, оролцооны хэлбэр** Туслах-**Т**, Хариуцан Гүйцэтгэх-**Г**, Хянах-**Х**, Шийдвэрлэх-**Ш** |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.1. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдан зохион байгуулах, үр дүнг тооцох;<br>1.2. Хууль тогтоомж, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтнаас гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журам, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой төрлийн ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох, тайлагнах;<br>1.3. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж, алба хаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;<br>1.4.Цагдаагийн бусад албад, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах ажлыг удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавих, холбогдох дүрэм, журам, заавар, зөвлөмжийг боловсронгуй болгоход санал хүргүүлэх, биелэлтийг хангах;<br>1.5.Цагдаагийн байгууллагаас тавих захиргааны хяналтын үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах;<br>1.6.Олон нийтийн цагдаагийн ажилтны үйл ажиллагаанд хяналт тавих;<br>1.7.Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, Иргэний зөвлөл, иргэдэд нийтийн хэв журам хамгаалах тасгийн чиг үүрэг, хэв журмын нөхцөл байдал, цагдаагийн алба хаагчдын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаар мэдээлэл, ажлын тайлан, санал, танилцуулга бэлтгэн тайлагнах;<br>1.8.Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, үйл ажиллагааны арга зүйг тодорхойлох, харилцан уялдаа бүхий цогц арга хэмжээг зохион байгуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах, санал, танилцуулга, төсөл хөтөлбөр бэлтгэх, тайлагнах;<br>1.9.Нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж байгаа гэмт | Хуульд заасан чиг үүргийн хэрэгжилт хангагдаж, ажлын үр дүн бодитой үнэлэгдэж, үйл ажиллагаа сайжирна.. | Г<br>Г<br>Г ,Х<br>Г ,Х<br>Г ,Х<br>Г ,Х<br>Г ,Х<br>Г ,Х |

| | | | |
|---|---|---|---|
| | хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, хамтран ажиллах, санал, танилцуулга, төсөл хөтөлбөр бэлтгэх, тайлагнах;<br>1.10. Эрүүлжүүлэх, саатуулах /баривчлах/ байрны үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох стандарт, дүрэм, журам, заавар, зөвлөмжийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах;<br>1.11.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм сахиулах, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах, гэрч хохирогчийг хамгаалах, жагсаал, цуглааныг албадан тараах, нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтыг нэгтгэн зохион байгуулах, удирдлагаас өгсөн үүргийг бүрэн хэрэгжүүлэх;<br>1.12.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд заасан цагдаагийн байгууллагын үүргийг нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэн хэрэгжүүлэх, зохион байгуулах;<br>1.13.Гамшиг, ослын үед цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх үүргийг нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөвлөх, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч дадлага, сургалт зохион байгуулах;<br>1.14.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, гадаад орнуудын туршлагыг судлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал, танилцуулга нэгтгэж хүргүүлэх. | | Г,Х<br>Г,Х<br>Г,Х<br>Г,Х<br>Г,Х<br>Г,Х |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 2.1.Нэгжийн нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;<br>2.2.Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэгтэй алба хаагчдын үйл ажиллагааны ажлын дүн мэдээ, гүйцэтгэлийг сар, улирал, хагас, бүтэн жилээр дүгнэж, дүн шинжилгээ хийх;<br>2.3.Гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, бүртгэл, судалгаанд үндэслэн нутаг дэвсгэрийн хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаандаа ашиглах;<br>2.4.“Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар”-ын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;<br>2.5.Албаны галт зэвсэг, техник, тусгай хэрэгслийг бүртгэх, олгох, хадгалах, хяналт тавих, журмын хэрэгжилтийг хангуулах, хүч хэрэгслийн тооцоо, судалгаа бүртгэл хөтлөх, танилцуулах; | Нийтийн хэв журам хамгаалах ажлын үр дүн бодитой үнэлэгдэж, үйл ажиллагаа сайжирна. | Г,Х<br>Г,Х<br>Г,Х<br>Г,Х<br>Г,Х |

| | | | |
|---|---|---|---|
| | 2.6.Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн хэв журам хамгаалах нэгжийн бүтэц, орон тоо, шаардагдах хүн хүч, техник, тусгай хэрэгслийн судалгаа хийх, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;<br>2.7.Байгууллагын дотоод журмыг мөрдүүлж, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, мэдлэг, ур чадвар, бие бялдар, сахилга, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчих, авилгаас урьдчилан сэргийлэх, ажлуудыг зохион байгуулах, үр дүнг тооцох, танилцуулах;<br>2.8. Хариуцсан нэгжүүдийн алба хаагчдын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцох, алба хаагчдын мэдлэг, ур чадвар, бие бялдар, сахилга ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх;<br>2.9. Албанаас зохион байгуулж буй албаны сургалт, соён гэгээрүүлэх ажилд алба хаагчдыг бүрэн хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;<br>2.10. Хариуцсан нэгжийн хэмжээнд ажлын байранд чиглэсэн дотоодын сургалт, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөж, хэрэгжилтийг хангах;<br>2.11.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасан нийтлэг шаардлагын дагуу шинээр томилогдсон алба хаагчид халамжлан хүмүүжүүлэгч-дадлагажуулагч багшийг томилж, ажлын байранд сурган дадлагажуулах, дасан зохицуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэн, гэрээ байгуулан зааварчилга өгч, үр дүнг тооцох;<br>2.12.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан заавар, зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлэх, зааварчлах удирдлагын баримт бичгийг боловсруулах, бүрдүүлэх. | | Г ,Х<br>Г ,Х<br>Г ,Х<br>Г ,Х<br>Г ,Х<br>Г ,Х<br>Г ,Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | **Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:**<br>1.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.<br>2.Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтийг хангах<br>3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах<br>4.Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх<br>**Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:** | Ажлын байрны зорилго, зорилт хангагдаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээлгэсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана. | Г<br>Г<br>Г<br>Г |

| | | | |
|---|---|---|---|
| | 1.Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд сахих;<br>2.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах. | | Г<br><br>Г |

## III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | | |
|---|---|---|
| **Боловсрол** | -Дээд боловсролтой, бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй | |
| **Мэргэжил** | -Эрх зүй /0421/, Аюулгүй байдал судлал /103901/, Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/, | |
| **Мэргэшил** | -Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх. | |
| **Туршлага** | Цагдаагийн байгууллагад 8-аас доошгүй жил ажилласан, ахлах, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх. | |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах | -Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах -Удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах, удирдах чадвартай<br>-Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх |
| | Дүн шинжилгээ хийх | -Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, дүгнэх<br>-Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх |
| | Асуудал шийдвэрлэх | -Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх |
| | Манлайлах | -Ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дуурайлал үзүүлэх<br>-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах<br>-Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх. |
| | Бусад | |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

| **Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:**<br>Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга | |
|---|---|
| **Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:**<br><br>Батлагдсан орон тоо. | **Бусад харилцах субъект:**<br><br>**Шууд харилцах:**<br>Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан.<br><br>**Шууд бус харилцах:**<br>Төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/. |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<table>
<tr><th>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</th><th>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</th></tr>
<tr><td>Албан тушаал:<br><br>ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН<br>ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА<br><br>Т.ГАНЗОРИГ<br><br>2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр</td><td>Байгууллагын нэр:..................<br><br>Шийдвэрийн огноо:.................<br><br>Дугаар:...................................</td></tr>
</table>

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр.

Дугаар: А/401

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

**Танилцсан:**

| |
|---|
| Танилцсан албан тушаалтан: . . . . . . .. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . |
| 20... оны .... дугаар сарын ....-ны өдөр |